

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-16

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох 3-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 14 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Галбадрах;
Чөлөөтэй: Ч.Анар, С.Цэнгүүн.

Нэг.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Төлбөр тооцооны хэлтсийн дарга В.Рэнцэнханд, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Дотоод аудит, хяналт шинжилгээний үнэлгээний хэлтсийн дарга Г.Отгонбаяр, Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтсийн дарга Б.Лхагва-Очир, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Т.Золбоот, Д.Энхсайхан, Ц.Лут-Очир, Ж.Жамсрандорж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтсийн дарга Б.Лхагва-Очир нар тус тус танилцуулав.

Мөн Байнгын хорооны дарга Ж.Золжаргал мэдээлэл танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, А.Ганбаатар, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтсийн дарга Б.Лхагва-Очир нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 55 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
11 цаг 14 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Мөн хүрэлцэн ирсэн Сангийн яамныхан болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хамт олондоо мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 54,5 хувьтай бүрдсэн учраас 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдааны ирцийг танилцуулъя. Чинбатын Анар гишүүн чөлөөтэй, Галбадрах гишүүн чөлөөтэй, Энхбаярын Батшугар гишүүн ирсэн байна, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн, Жаргалсайханы Золжаргал ирсэн, Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн, Чинбатын Номин гишүүн ирсэн, Чинбатын Ундром гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байгаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Сангийн сайдын мэдээллийг сонсох гэж. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд, хэлэлцэх асуудал дээр санал асууна. Гишүүдээс хэлэлцэх асуудал дээр санал байгаа билүү? Хэлэлцэх асуудал дээр санал байхгүй байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой ажлын хэсгийнхнийг танилцуулъя. Сангийн яамны ТНБД Ганбат, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Цогбадрах байхгүй байна тийм ээ, байхгүй, байгаа. Төрийн сангийн газрын дарга Цогбадрах, Төрийн сангийн Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Рэнцэнханд, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Отгонбаяр, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтсийн дарга Лхагва-Очир, Золбоот Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Энхсайхан Улсын Их Хурлын гишүүний гишүүн зөвлөх, Лут-Очир Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Жамсрандорж Улсын Их Хурлын гишүүний зөвлөх гээд ийм бүрэлдэхүүнтэй хүмүүс байна.

Танилцуулгаа эхэлнэ. Тэгээд үндсэн зорилго маань бид Сангийн яаманд албан бичгээр хандаад мэдээлэл авсан байгаа. Гишүүдэд түгээж өгсөн, онлайнаар бас түгээсэн. Монгол Улсын Үндсэн хуулийн байдаг төрийн ил тод байдлын тухай зарчим, Төсвийн хууль дахь төсвийн ил тод байдлын тухай зарчим, тэгээд тэр мэдээллүүд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгагдсан байдаг, бас журмууд байсан. Тэгэхээр эдгээр ажлыг хэрэгжүүлэх веб сайтаар дамжуулж олон нийтэд нээлттэй хүргэх талаар нэлээд ажлууд хийгдсэн байдаг, байгаатай бид танилцсан. Тэгээд энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, цаашдаа хэрхэн сайжруулах, хуулийн заалтууд дээр яг бүрэн хэрэгжсэн нь ямар байгаа, цаашдаа анхаарах нь ямар заалтууд байна вэ гэдэг дээр анхаараад та бүхэн танилцуулгаа хийнэ үү гэж хүсье. Сангийн сайд

Жавхлангийн танилцуулгыг Төрийн нарийн бичгийн дарга Ганбат танилцуулна. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

Ж.Ганбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Шилэн дансны тухай хууль 2014 оны 7 сарын 1-ний өдөр батлагдаж, 2015 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байгаа. Энэ хууль батлагдсантай холбогдуулан ЗГ-аас 2016 онд шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартад тогтоох журмыг шинэчлэн баталж мөрдүүлсэн байгаа. Тэгээд Шилэн дансны хууль, журмын хүрээнд нийтдээ 6417 байгууллагын 12813 хэрэглэгчид 41 төрлийн мэдээллийг бүтэн жил, хагас жил, улирал, сар, долоо хоног тутам шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа.

Сангийн яам нь хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд цахим хуудасны шинэчлэл сайжруулалтыг хариуцан, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж буй бусад томоохон системүүдтэй холбогдож, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ нийт цахим хуудсанд оруулах мэдээллийн 60 гаруй хувийг автоматжуулсан байгаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагын мэдээлэл оруулах үүрэг бүхий албан хаагчдын ажлын ачааллыг хөнгөвчилж, мэдээллээ нийтлэхэд цаг хугацаа хэмнэх, мэдээллийн үнэн зөв байдал хангаснаар төрийн сангийн төлбөр тооцооны системд хийгдсэн гүйлгээ нь шилэн дансны цахим хуудсанд шууд автоматаар тавигддаг болгосон байгаа.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 8.1 дэх заалтын дагуу шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналт, тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлдэг. 8.2-т төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудитын нэгжээр хэрэгжүүлэхээр заасны дагуу үүнийг хэрэгжүүлж ажиллаж байгаа. Мөн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9.8-д заасны дагуу шилэн дансны хөтлөлтийн байдалд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр төсвийн ерөнхийлөн захирагчдын шилэн дансны хөтлөлт 2021 онд 96,2 хувь, 22 онд 96 хувь, 23 оны байдлаар 95,2 хувьтайгаар тус тус үнэлэгдсэн байгаа. 24 оны 11 дүгээр сарын байдлаар Шилэн дансны хөтлөлт 96,5 хувьтай байна гэж ингэж үнэлэгдсэн байгаа. Товчхондоо мэдээлэл өгөхөд ийм байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Танилцуулга шилэн дансны, шилэн данс болон ил тод цахим мэдээллийн платформын талаар танилцуулга байхгүй юм байна тийм ээ? Микрофоноо авах уу та? Наана чинь дугаар байна уу? 6, дугаар 6, та 4 минутад багтаагаад товчхон гүйлгээд харуулчих уу.

Б.Лхагва-Очир: Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амгаланг эрье. Сангийн яамны Санхүүгийн мэдээлэл, технологийн хэлтсийн дарга Лхагва-Очир. Танилцуулга хийе. Шилэн дансны цахим хуудас руу shilendans.gov.mn гэдэг сайтаар олон нийт хандаж ордог. Тэгээд байгууллага цэсэд болохоор бүх шилэн дансанд бүртгэлтэй байгаа нийт байгууллагын статистик тоон мэдээллүүд харагдаж байдаг. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагыг болохоор ингээд 6, 8 төрөлд, 7 төрөлд хуваасан байдаг. Тэгээд эдгээрийг байгууллага тус бүрээр нь хэдэн ширхэг байгууллага бүртгэлтэй байгаа вэ гэдгээ энэ зэсээс харж болдог. Тэгээд энэ зэсээс болохоор бүх байгууллагаа юугаар нь нэрээр нь хайх, хайгаад

тухайн байгууллагын мэдээллийг харах боломжтой. Энд жишээ нь Сангийн яам гээд хайнгуут тухайн мэдээлэл нь гарч ирнэ. Тэгээд байгууллагынхаа нэр дээр дарангуут тухайн байгууллагын байршуулах хуулиар байршуулах ёстой мэдээллүүдийн жагсаалт гарч ирнэ.

Энэ мэдээллийн жагсаалтыг болохоор шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн төрөл, стандартыг тогтоох тухай Засгийн газрын тогтоолоор батлагдсан маягтын дагуу шилэн дансны систем дээр тохируулж өгсөн байдаг. Энэ мэдээллүүд нь болохоор нөгөө Шилэн дансны тухай хууль болон журам дээр заасны дагуу улирал бүр зарим мэдээлэл нь сар бүр, зарим мэдээллээ улирал бүр, зарим мэдээллээ жилд нэг удаа, жишээ нь батлагдсан төсвөө жилд нэг удаа, дараа жилийн төсвийн төслөө нэг удаа гэдэг байдлаар оруулдаг. Сар бүр оруулах мэдээлэл дээрээ энд нь ингээд дээр нь сарууд нь байж байдаг 1-ээс 12 сар. Энэ саруудынхаа доорх сонголт дээр орохоор дэлгэрэнгүйгээрээ тухайн сард ямар мэдээллүүд байгаа гэдэг нь дэлгэрэнгүй жагсаалтаар ордог.

Тэгээд тухайн улирал бүрд оруулах мэдээлэл нь тухайн улирлынхаа энэ 4 дүгээр сардаа харагддаг. Жил бүрийн хагас жилийн мэдээлэл нь болохоор яг 6 дугаар сардаа нэг удаа харагдана. Дээрээс нь тусгай сангууд гээд тусдаа тийм цэс байдаг. Түүн дээр болохоор Засгийн газрын тусгай сангуудын талаарх саяын мэдээлэл байна. Ялгаагүй нөгөө юун дээрээ дарангуут тухайн тусгай сангийн сангууд болохоор ямар мэдээллээ ил тод болгох ёстой гэдэг маягтынхаа дагуу маягтууд нь харагддаг.

Мөн нээлттэй өгөгдөл гэж цэс шинээр үүсгэсэн. Энэ нээлттэй өгөгдлийн мэдээлэл нь болохоор нөгөө нээлттэй эхийн олон улсын стандартын дагуу мэдээллийг ил тод болгох шаардлагын дагуу үүсгэсэн цэс байгаа. Энэ цэсээс болохоор тухайн мэдээллийг он оноор нь, улирлаар нь, сараар нь филтердээд харах боломжтой, нэгтгэсэн дүнгээр харах боломжтой ийм цэс байгаа. Сараа сонгоод, улирлаа сонгоод, тэгээд эндээсээ нөгөө байгууллагынхаа төрлийг сонгоно ямар мэдээлэл оруулах юм үзүүлэлт нь. Тэгээд тухайн байгууллагын ямар, ямар мэдээллийг нь харуулах юм гэдэг регистрийн дугаар, нэр.

Ж.Золжаргал: Нэмж цаг авах уу та, болчихсон уу? Баярлалаа. Тэгвэл гишүүдээс асуулт асуух цаг эхэлнэ. Тэгэхдээ түүнээс өмнө хурал даргалж байгаагийн хувьд би нэмэлт мэдээлэл өгөөд, асуулт асуугаад, саналаа хэлчихье гэж бодож байна. Нэг товчхон танилцуулга байгаа, манайхан залгаад өгөх үү? Сангийн яаман дээр маш их мэдээлэл тоо байгаа. Тэр нь интернэт рүү энэ веб сайт руу, шилэн данс, ил тод руу их хэмжээний мэдээллүүд өгөгдөөд ингээд ордог. Энэ дээр нэлээн их ажил хийгдэж байгааг нь хийгдсэн байгааг нь тэмдэглэж хэлмээр байна. Нэлээн орж бид судалсан.

Тэгээд 1 санал байна. Цаашдаа илүү их ойлгомжтой, хялбар, хүн хэрэглэхэд хялбар болгох хэрэгцээ шаардлага байгаа гэж харагдаад байгаа юм. Энэ төсвийн тухай хуулийн 6.5.1 дээр төсөв бол нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байхаар мэдээлэх гэдэг ийм заалт байгаа юм. Тэгэхээр тэрний хүрээнд та бүхэндээ нэг санал асуултууд байгаа юм. Эд нарыг гүйлгээд явуулчих уу дараагийнхыг нь, дараагийнхыг нь явуулаарай слайд. Энэ ингээд төслийн ил тод байдлыг сайжруулах талаар хуулийн заалтууд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Төсвийн тухай хууль гээд зарим заалтыг нь жишээ болгоод энд харуулж байгаа юм л даа. Тэгэхээр төсөв маань хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг мэдээлж байх шаардлагатай байна. Сар тутмын

нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аудитын дүгнэлт, төсвийн хэмнэлт, хэтрэлт, ингээд хэмнэлт, хэтрэлтийг жишээ нь шалтгаантай нь хамт улирал бүр Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх, тэгээд л бонд, зээлийн баталгаа, ЗГ-ын зээлийн ашиглалт гэх мэтчилэн иймэрхүү их тодорхой мэдээллүүд байгаа.

Дараагийнхийг нь явуулчих. Shilendans.gov.mn веб сайтаар жишээ нь ороод харахад хагас жил бүр гэдэг хэсэгт нь ороод ингээд санхүүгийн тайланг татаж аваад тэнд харуулчихсан байна. Ингээд гарч ирж байх жишээтэй. Дараагийнх. Аудитын дүгнэлт гээд ингээд татаж гаргаж ирээд, энд жишээ нь хэзээнийх юм, 24 оны 4 дүгээр сарын 23 оны аудитын дүгнэлтийг 24 оны 4 дүгээр сарын 29-нд оруулсан. Ингээд татаж аваад харж болж байгаа. Дараагийнх нь, төсвийн хэмнэлт, хэтрэлт шалтгаан гээд, үүгээр ингээд хайж ороод дараа сарын 8-ны дотор мэдээлэх ёстой. Энэ ингээд жишээ нь байгууллагаар нь Сангийн яамыг жишээ болгоод аваад үзэхээр ингээд ороод excel file-ийг нь татаж аваад, энэ ингээд их боломжийн мэдээллүүд байна гэж.

Дараагийнх нь орлогын, төвлөрүүлэх орлогын хэмжээ гээд гарч ирж байгаа. Excel-ээр нь татаж авч болдог. Дараагийнх нь гадаадын зээл, тусламжийн зарцуулалт гээд их тийм мэдээлэлтэй хэсэг байгаа. Тэгэхдээ энэ дээр жишээлбэл ингээд нөгөө нэр байхгүй, гүүр зам, туннел юу байдаг юм, тэд нар нь байхгүй бүгд гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр гэдэг адилхан нэртэй хойноо тоотойгоо иймэрхүү байх жишээтэй. Ерөнхийдөө, дараахыг нь явуулчихаарай. Мэдээлэл их маш олон их мэдээлэл байна. Зарим нь хангалттай хэмжээнд, зарим нь хангалтгүй хэмжээнд, зарим нь тодорхойгүй, зарим нь дутуу орсон, зарим нь хугацаандаа ордоггүй, зарим нь мөрддөг, байгууллага, салбар яамдаасаа хамаараад байх шиг байгаа юм. Тэгээд энэ Төсвийн тухай хуулийн ил тод байдлыг хангагдсан байх гэдэг гол заалт байгаа. Дараагийнхыг нь эргүүлээрэй. Нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх гэж нэг гол заалт байна. Нийтийн оролцоог хангах, олон нийт хяналт тавих боломжоор хангах, нийтийн саналыг харгалзан үзэх, саналыг харгалзан үзсэн тухай дүнг тухай бүр мэдээлж байх гээд иймэрхүү заалтуудыг энэ цаашдаа мэдээлэлдээ их анхаарах хэрэгтэй юм болов уу гэж харагдаж байгаа.

Дараагийнх нь, тэгээд энэ илүү их хялбар, ойлгомжтой байхын тулд яах вэ гээд нэг ийм санал байна л даа. Эргүүлээрэй, тэгэхээр янз бүрийн форматаар хүснэгт excel-үүд оруулж болно. Монгол Улсын төсвийн батлагдсан төсвийн тухай хууль байгаа. Тэгээд хууль дээр орсон хүснэгтүүд, зардлын бүтэц хавсралтууд байгаа. Үүнийг гишүүдэд мэдээлдэг төсвийн төсөл дээр төслийн ном дээр мөн ижил загвараар явж байгаа. Тэгэхээр тэр загвараараа нийтэд мэдээлдэг веб сайт дээрээ мэдээллээ өрвөл маш их ойлгомжтой байх юм болов уу гэж. Жишээлбэл энэ веб сайт руу ороход эхний 4, шууд эхний нүүрэн дээр нь ерөөсөө л орлого, урсгал зардал, хөрөнгийн зардал, тусгай сангууд гэсэн дөрөвхөн цэс байж байна гэж төсөөлье. Тэгээд орлого дээр нь дарахаар ингээд дараа руугаа шилжчихдэг.

Дараагийнх нь явуулаадахъя. Жишээлбэл орлого Ерөнхийлөгч гэхээр энэ Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйл дэх хүснэгт байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын орлого 185 сая төгрөг гээд. Энэ дээр нь дарахаар эх үүсвэр 1, 2, 3 гээд ингээд, тэгээд эх үүсвэр 1 дээр нь дарах юм бол, Ганбат даргаа та наашаа суувал арай эвтэйхэн байх юм болов уу танд, эргэж харахаар, за. Гарч ирээд байхаар.

Дараагийнхыг нь явуулаарай. Ингээд урсгал зардал гэдэг рүү нь орохоор зэрэг жишээлбэл дээрээс 2 дахь нь. Улсын Их Хурлын дарга гээд 163 тэрбум төгрөг

байгаа, ингээд энэ дээрээ дарлаа. Тэгэхээр зардлын төрөл 1, 2, 3 гэж. Тэгээд аль нэг дээр нь дарахаар гүйцэтгэл дүнгээр, хувиараа гардаг гээд. Тэгээд энэ бүх би мэдээллүүд маань бүгд аль хэзээний орчихсон бас нэг газар ингээд цахимаар байж байгаа. Зүгээр гол нь нөгөө хялбархан яаж ойлгомжтой болох вэ гэдэг дээр санаа хэлээд байгаа юм шүү.

Дараагийнх нь, урсгал зардлыг нь харьяа байгууллагуудаар нь дараагийнх нь ангилал дээр нь ингээд. Тэгээд байгууллага 1, 2 гээд. Байгууллага 2 дээр дарахаар байгууллага 2-ын урсгал зардал нь цалин, nds, томилолт, түрээс, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэх мэт задаргаатай. Тэгээд нөгөөх дээрээ дарахаар цаашаагаа дамжаад гүйцэтгэл дүнгээр, хуваарь ингээд гарч ирдэг. Дараагийнх нь, дараагийнх нь болохоор нөгөө хөрөнгийн зардал. Хөрөнгийн зардал дээр жишээ нь ингээд Монгол Улсын Ерөнхий сайд хөрөнгийн зардал 259 тэрбум төгрөг. Энийгээ ингээд дарахаар барилга байна уу, барилга 1, 2 тоног төхөөрөмж гэх мэтчилэн задаргаа нь гарч ирнэ. Тэгээд барилга 1, 2 дээр нь дарахаар үндэслэл, ач холбогдол, гүйцэтгэгчийн талаар мэдээлэл, гүйцэтгэлийн байдал, төсөв хэтэрсэн, хэмнэсэн гэх мэтчилэн ингээд цаашаагаа орж ирдэг. Энэ мэдээллүүд нь аль хэзээний бүртгэгдчихсэн байж байгаа. Тэгэхээр иймэрхүү хялбаршуулсан байдлаар.

2 дугаарт нь бас нэг асуулт болгоод төгсгөлд нь та бүхнээс асуухад энэ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүртгэх, кодлох, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам гээд хэрэгжиж байгаа. 2018 оны 250, 95 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам, аргачлал гээд байгаа. Тэгэхээр энэ аргачлалуудын хавсралт, түүн дээр байгаа маягтуудыг энэ санал болгоод жишээ болгоод байгаа иймэрхүү хялбаршуулсан байдлаар нийтэд хүртээх л хэрэгцээтэй байна гэж хараад байгаа юм.

Дараагийнх нь, энэ ингээд жишээ нь тусгай сангууд гэдэг ангилал руу нь орохоор дотроос нь ингээд сонгоод, энэ бас л төсөв дээр Төсвийн тухай хууль дээр орсон хавсралт хүснэгт авто улсын авто замын сан гээд 129 тэрбум төгрөг. Энэ дээр ингээд дарахаар орлого, зарлага нь ямар түвшинд байна вэ гэх мэтчилэн ингээд задрах жишээтэй. Тэгэхээр энэ бүхнийг харуулж байгаа зорилго нь мэдээлэл маш их байна, маш их мэдээлэл цахимжсан байна. Ороод хэрэглэхэд хүн ойлгоход их төвөгтэй байна. Маш их нааш, цаашаагаа 2, 3 веб сайт дамжиж явах нь байна. Тэгэхээр тэр түвшний нарийн мэдээлэл хангалттай сайн орсон гэж зарим байгууллагаараа. Нийтэд ил тод байх, ойлгомжтой байх гэдэг нь хуулийн үндсэн зарчим. Төсвийн тухай хууль дээр ч бий, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дээр ч бий, Шилэн дансны тухай хууль дээр ч бий. Үүнийг хэрэгжүүлэхдээ веб сайт дээр оруулахдаа user experience UX гээд одоогийн энэ хэллэгээр хэлээд байгаа тийм хүний хүнд их ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, гол дүнгээ харж болохоор ийм хувилбарт оруулах шаардлага байна л гэж харж байгаа юм.

Тэгээд энэ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас сайдын зөвлөх Тулгат ирсэн байгаа. Түрүүн ирц дээр хэлээгүй. Тэгээд энэ талаар бас та бүхэн анхаараасай гэж энэ зорилгоор өнөөдрийн асуулт, хариулт, мэдээллийг аваад асуулт, хариулт явуулж байгаа юм гэдгийг бас нэмж хэлье. Гишүүд асуулт асуух уу? Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхбат гишүүн, Ганбаатар гишүүн, Золжаргал гэсэн ийм 3 хүн байна. Асуулт бол Сангийн яамны танилцуулгатай холбоотой явна. Минийх бол санал байсан шүү.

Ц.Мөнхбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ шилэн данснуудыг веб сайтад байрлуулаад явдаг. Тэгээд гүйцэтгэл нь хувиар тодорхойлогдоод үздэг. Тэгээд 1 ийм юм асуух гэсэн юм. Энэ 100 хувийн гүйцэтгэлтэй байгаад байгаа шилэн дансаа хөтлөөд байгаа ийм байгууллагууд ямар урамшуулал авдаг юм бэ? Тэр огт хөтлөхгүй байгаа нөхдүүдэд ямар хариуцлага тооцдог юм бэ гэдэг энийг асууя. Энийг асуучаад тэгээд дараа нь тодруулга авъя.

Ж.Золжаргал: Хариултыг 4 номер Ганбат дарга өгнө.

Ж.Ганбат: Шилэн данс өөрөө хууль шүү дээ. Бид хууль хэрэгжүүлэх үүрэгтэй. Бүх төсвийн байгууллагуудыг, бүх шатны төсвийн захирагч нар бол шилэн данс хөтлөх үүрэгтэй. Энийг хөтлөөгүйн төлөө хэрэгжилтээр нь яах вэ Үндэсний аудитын газар аудит хийгээд, хяналтаа тавиад хэрвээ тэр тухайн байгууллагууд дээр удаа дараа зөрчил үүсвэл Үндэсний аудитын газраас тэрийг хөтлөөгүй албан тушаалтнууд дээр хариуцлага тооцож, ажлаас нь чөлөөлөх хүртэл арга хэмжээг авахаар ийм санал гараад, энэ бол эрхтэй аудит. Тэрнээс бид юу гэдэг юм шилэн дансыг чи сайн хөтөлж байна гэдэг дээр нь урамшуулал байхгүй шүү дээ. Харин үүнийг бүүр сайн хөтлөх ёстой байхгүй юу. Бид Сангийн яам эндээс 5 сая төгрөгөөс дээших гүйлгээнүүдийг бүгдийг нь автоматаар тавьдаг ийм л болгочихсон.

Өөрөөр хэлбэл үүн дээр хэн нэгэн албан тушаалтан тэр хүнийг нууж хаагаад байх юм байхгүй. Бид сан юун дээр манай Төрийн сан дээрээс гүйлгээ хийгдлээ л бол тэр шууд автоматаар шилэн данс дээр тавигддаг ийм программынх нь хувьд ийм тохиргоо хийгээд ингэчихсэн. Энэ дээр бол яахгүй. Зүгээр яах вэ яг нийтлэг нэг байгууллагууд дээр мэдээж ингээд төсөв бүтэн жилээр санхүүгийн тайлан гараад, энэний дараа Үндэсний аудитаас бол бүх шатны төсөв дээр аудит хийгддэг. Тэгээд яах вэ зөрчилтэй, зөрчилгүй энэ тэр гээд, мэдээж яах вэ санхүүгийн зөрчилгүй гарч байгаа байгууллагууд дээр тэр чинь ажлаа л үнэлүүлж байгаа шүү дээ. Санхүүгийн хувьд зөрчилтэй бол түүн дээр удаа дараа зөрчил гаргаж байгаа байгууллагуудын удирдлагуудыг солих, санхүүгийн ажилтнуудыг нь өөрчлөх иймэрхүү байдлаар арга хэмжээнүүд авагдаад байдаг. Тэрнээс биш урамшуулал гэж юм байхгүй.

Ж.Золжаргал: Мөнхбат гишүүн тодруулга.

Ц.Мөнхбат: Анзаарахад шилэн данс хөтлөөд байдаг байгууллагууд байдаг юм. Хөтлөхгүй байгаад байдаг нөхдүүд бас байгаад байдаг юм. Ерөөсөө байнгын. Тэгээд хөтлөхгүй байгаа нөхдүүд дээр яг хариуцлага бодитой тооцдог уу, үгүй юү? Мэдээж аудит тэгвэл хариуцлагыг нь тооцох тэр механизмыг нь гаргаж ирэх ёстой юм байна.

2 дугаарт нь төрийн байгууллагууд бол учиртай ер нь гайгүй байх шиг байдаг. Энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, энэ тусгай сангууд дээр ер нь энэ шилэн данснуудын хэрэгжилт хэр байдаг вэ? Энэ дээрээс ер нь хариуцлага тооцуулж, шилэн дансаа хөтөлсөн, хөтлөөгүй гэдгээс хариуцлага тооцуулж байсан тийм тохиолдол байна уу гэж асуух гэсэн юм.

Ж.Золжаргал: Нэмэлт асуултад нэмэлт хариултыг хаана өгөх билээ? 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

Ж.Ганбат: Энэ дээр яг хууль дээрээ ийм заалт байдаг юм байна. Шилэн дансны хуулийн энэ 10.1 дээр нь энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь

гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад шилжүүлдэг. Гэмт хэргийн шинжгүй гэж үзэж байгаа бол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ гэдэг ийм заалттай байдаг юм байна. Шилэн дансны хуулийг төрийн өмчийн компаниуд дээр ч гэсэн ялгаагүй бүх шатны төсвийн захирагч дээр, төрийн өмчийн компани, төсвийн байгууллагууд дээр Үндэсний аудитын газраас хяналтыг нь тавиад, тэгээд саяын тэр хуулийн заалтын дагуу гэмт хэргийн шинж чанартай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлээд, үгүй бол тэр хуулийнхаа дагуу арга хэмжээг нь авч хэрэгжүүлдэг юм байна. Энэ дээр яг аудитын тайланг уг нь аудитаас байсан бол яг ийм хэчнээн төрлийн байгууллагууд дээр яг арга хэмжээ авч байсан гэдэг илүү тодорхойлно. Яг аудитын тайлан одоо алга байна.

Ж.Золжаргал: Ганбаатар гишүүний микрофоныг нээж өгнө үү, Ганбат дарга, Ганбат даргын. Асуулт дараагийнх нь болчихсон. Ганбаатар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

А.Ганбаатар: Баярлалаа. Өдрийн мэнд хүргэе. Би болохоор нөгөө хэрэглэгч талаасаа буюу энэ шилэн данс Нийтийн мэдээлэл ил тод байх тухай хуулийн дагуу иргэд хэр мэдээлэлтэй болж байгаа вэ гэдэг талаар асуух гээд байгаа юм. Энэ Глоб Интернэшнл ТББ-ын хийсэн судалгаагаар Нийтийн мэдээлэл ил тод байдлын тухай хуулиар мэдээлэл хариуцагч байгууллага нь нэг ийм 68 төрлийн мэдээллийг байнга нээлттэй байх ёстой гэж зохицуулсан юм байна. Эдгээрээс 44 мэдээлэл хариуцагч байгууллага нь бол, байгууллагад хамаарч буй нь, хамаарч байгаа юм байна. Үлдсэн 24 байгууллага нь чиг үүргээсээ хамаараад ялгаатай мэдээ мэдээллүүд өгөх ёстой юм байна л даа. Тэгээд энэ судалгаа дээр гарснаар энэ мэдээллийг олж авч байгаа иргэдийн 52 хувь нь мэдээллээ ерөөсөө олж авч чадахгүй. Дээр нь нөгөө хуулиа, хуулийн танилцуулга гэх юм уу, сурталчилгаа муу байгаагаас хамаараад яаж мэдээлэл олж авахаа мэдэхгүй байна гэсэн нэг ийм судалгаа харагдаад байна.

Энэ судалгааг ямар хүрээнд хийсэн бэ гэхээр Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Баян-Өлгий аймаг, Орхон аймаг, Ховд аймаг, Хөвсгөл аймаг, үүн дотроо 2 дугаар эмнэлэг, Монросцветмет, Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн, Цэргийн эмнэлэг гэх зэрэг. Хөдөө орон нутгийнх аймгийн ЗДТГ, бусад хариуцсан байгууллагууд мэдээлэл хэрхэн авч байна гэдэг талаар хийсэн судалгаа дээр бид мэдээллээ өгч байгаа гэдгээ 52 хувь нь өгч байгаа гэж хэлсэн юм байна тухайн байгууллагууд нь. 48 хувь нь бид өгч чадахгүй байна гэж хариулаад, ингээд дүгнэлт нь иргэд болохоор мониторингд хамрагдсан 204 иргэний 63 хувь нь буюу ихэнх нь ерөөсөө мэдээлэл авч чадахгүй байна. Нийтийн мэдээлэл ил тод байх тухай хуулийн бол хэрэгжилтийг бид амсахгүй байна гэсэн хариулт өгөөд, 61 хувь нь бүүр зорьж очоод хүссэн мэдээллээ авч чадаагүй байна гэсэн хариулт өгөөд, 61 хувь нь ахиад төрийн байгууллагаас мэдээлэл авах эрх нь хуулиар баталгаажсан эсэхээ мэдэхгүй байгаад байгаа юм.

Тэгээд мониторингд хамрагдсан 205 төрийн байгууллагын 66 хувь нь шинээр батлагдсан хуулийн талаар хангалттай мэдээлэл өгөөгүй байгаад байгаа юм. Мэдээлэл хариуцагч байгууллагын хуульд заавал нээлттэй байлгахгаар заасан 44 төрлийн мэдээллийнхээ зөвхөн 52 хувийг ил болгосон гэж байгаа юм. Мэдээлэл хариуцагч байгууллага нь иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хүссэн мэдээллийн 45 хувьд нь огт хариу өгөөгүй байна гэсэн ийм судалгаа байгаад байгаа юм. Тэгэхээр миний юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр төрийн байгууллагууд Шилэн дансны хуулийнхаа дагуу, Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийнхаа дагуу мэдээллээ тавьдаг юм байна веб сайт дээрээ бол. Сая Золжаргал даргын тайлан

дээр харагдаж байна. Гэхдээ үүнийг нь нөгөө хүртэх ёстой иргэд, мэдээлэл авах ёстой иргэд нь авч чадахгүй байна. Би.../минут дуусав/

Ж.Золжаргал: Ганбаатар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

А.Ганбаатар: Би бодохдоо хуулийн сурталчилгаа энэ мэдээллээ иргэд рүүгээ ямар арга замаар авах талаар сурталчилгаа муу байна уу гэж хараад байна л даа. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр энэ талын мэдээллээ бол байнга мэдээлж байх ёстой. Ийм нөгөө зам, гүүр алга байгаад байна шүү дээ мэдээллээ олж авах. Бусдаар бол тавьчихдаг юм байна. Нөгөө талаасаа олж авдаггүй юм байна гэсэн ийм нэг тийм нүх харагдаад байна л даа. Энийг яаж холбох вэ? Энэ тал дээр ямар байдал, ажлаа яаж сайжруулах вэ гэдэг талаар та бүхэн танилцуулж өгөөч. Баярлалаа.

Ж.Золжаргал: 3 дугаар микрофон дээр.

М.Тулгат: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх Тулгат. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр энэ шилэн данстай холбоотой асуудал яригдаж байгаа. Шилэн данс маань бол shilendans.mn гээд сайтаар сайт дээр явагддаг. Сангийн яам хөгжүүлэлт болон зохион байгуулалтаа хариуцаад явдаг. Гишүүний асуултад ер нь энэ төрийн мэдээлэлтэй холбоотой бүхэлдээ иргэдэд ойлгомжтой байх талаас нь асуулт асууж байна гэж ойлгож байна.

Саяын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 68 төрлийн мэдээлэл гэдэг энэ зүйл маань shilen.gov.mn гэсэн ийм сайт дээр төрийн байгууллагууд мэдээллээ оруулаад явж байгаа. Үүнийг манай яамны зүгээс хариуцаад шилэн штаб байгуулаад энэ дээр төрийн байгууллагуудыг мэдээллээ оруулахыг нь шахаад ингээд явж байгаа. Ер нь гишүүний асуулттай холбогдоод хэлэхэд ер нь яг иймэрхүү сайтууд их олон энд, тэнд байгаад байгаа нь иргэдэд ойлгомжгүй болгочхоод байгаа юм. Жишээлбэл opendata гээд бас байж байгаа юм нээлттэй өгөгдлийн. Тэгэхээр цаашдаа нөгөө нэгдсэн веб сайт, тэгээд ер нь аль болохоор иймэрхүү мэдээллийн сайтуудыг нэгтгэх, ойлгомжтой болгох тал дээр яамны зүгээс бодлого барьж ажиллаж байгаа. Мөн гишүүний хэлсэн зүйл дээр цаашид анхаарч иргэдэд мэдээлэл өгөх энэ ажлыг эрчимтэй явуулах нь зүйтэй юм байна гэж ингэж ойлгож байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: 4 номерын микрофон.

Ж.Ганбат: Энэ олон улсын international budget survey гээд энэ байгууллагаас гаргадаг нэг ийм төсвийн ил тод мэдээ нээлттэй байдал гэдэг дээр судалгаа гаргадаг нэг олон улсын байгууллага байгаа. Энэний гаргасан судалгаагаар 2006 онд манайх нийт дэлхий дээр ингээд 10, хангалтгүй гэдэг оноо авч байсан. 2008 онд бага гээд, 2006 оноос эхэлж манай дээр ингээд судалгаа хийсэн байгаа. Тэгээд 2015 онд манайх нийт мэдээлэл бол хязгаарлагдмал, тэгээд иргэдэд, олон нийтэд мэдээлэл өгөхдөө сул гэдэг ийм байдалтай байсан. Одоо яг 2023 оны жилийн эцсийн байдлаар 62 буюу энэ хангалттай гэдэг ийм үзүүлэлт рүү орж ирээд, иргэдэд мэдээллээ, иргэдийн оролцоо иргэдэд мэдээллийг өгөх нь сул биш, бага гээд ингээд 19 рүү орж ирээд ингээд жоохон орон ахиад ингэж бол хөндлөнгийн ОУБ-аас манайхыг дүгнэсэн байгаа юм.

Ж.Золжаргал: 4 номерт нэмж хугацаа өгье.

Ж.Ганбат: Яах вэ иргэдийн оролцоог хангасан, иргэдэд мэдээллийг өгсөн, бид иргэдийн төсөв гээд нэг төсөв батлагдангуут бид төсвөө, батлагдсан төсвөө иргэдэд ойлгомжтой байдлаар зурган хэлбэрээр хэвлээд, iltod.gov.mn гэдэг дээр тавьж байгаа юм. Энийг яах вэ бид хэвлэж нэлээн эрчтэй тарааж байсан юм Дэлхийн Банкны санхүүжилт энэ тэрээр. Энэ ингээд уг нь яах вэ тодорхой эх сурвалжуудаа бол энийг ингээд иргэд ингээд ашиглаад сурчихсан нэг мэдээлэл, ил ингээд яг иргэдийн төсөв гэдэг нэртэй.

2 дахь нь Орон нутгийн хөгжлийн сан дээр сумд өөрөө, аймаг, нийслэл дээр нөгөө иргэдийн оролцоотой орон нутгийн төсвийг хөгжлийн сангийн төсвийг хэлэлцүүлдэг ийм жишиг нэлээн олон жил болчихсон байгаа. Иргэд өөрийнхөө сум, дүүрэг, баг, хороондоо ингэж төсвөө хэлэлцүүлдэг ийм жишиг тогтчихсон. Энэ нэлээн хэвшчихсэн байгаа шүү дээ. Яг энд бол иргэд яг өөрсдөө яг хийгдэх хөрөнгө оруулалтын болон төсвөө иргэд өөрсдөө.../минут дуусав/

Ж.Золжаргал: Ганбаатар гишүүн тодруулна.

А.Ганбаатар: Тэгээд ОУБ-ын дүгнэлт нэг талаасаа гараад байх шиг байна. Энэ ОУБ-ын төсөл хэрэгжүүлж байгаа Монгол дахь судалгааны байгууллагын хийсэн судалгаа дээр бас арай өөр тоо гараад байна л даа. Тэгээд энэ 2 талдаа зөрсөн тоо харагдаад байгаа юм. Тэгээд яах вэ энэ дээр дүгнэлтийг нь хэлэхэд бол ингэж байна. Мэдээлэл авахаар төрийн байгууллагад хандсан уу гэхээр хандах учраа олохгүй байна гэж 63 хувь нь хэлээд байгаа юм. Яах вэ энэ хандсан иргэд дотроосоо 61 хувь нь хүссэн мэдээллээ авч чадаагүй, 23 хувь нь гүйцэд мэдээллээ авсан, 16 хувь нь дутуу ойлгомжгүй, хагас дутуу авсан гэсэн нэг ийм тоо баримт байгаад байгаа байхгүй юу судалгаа дээр гарчихсан. Тэгэхээр миний хэлэх гэж байгаа санаа нь төрийн байгууллагууд маань шилэн дансны гэдэг юм уу мэдээллээ тавьдаг юм байна, тэрийг ойлгож байна. Үнэлэлт дүгнэлтээ ч авдаг юм байна. Энэ дээр шүүмжлэлтэй хандаагүй. Зөвхөн энэ мэдээлэл авах гэж очиж байгаа иргэдийн арга замыг яаж хөнгөвчлөх вэ? Орон нутагтаа байна уу, төвдөө байна уу тийм ээ?

Ж.Золжаргал: Нэмэлт хариулт өгье, 4 дүгээр микрофон.

Ж.Ганбат: Иргэдэд мэдээлэл өгөхийг сүүлийн үед Засгийн газраас сүүлийн хэдэн жил цахимжуулахыг бид асар эрчтэй явуулж байгаа шүү дээ. Цахимаар мэдээллийг авахыг уриалж байгаа, цахим дээр байршуулж байгаа. Яах вэ ийм байгаад байгаа, одоо жишээ нь манай яамны веб сайт дээр тавигдсан мэдээллүүдийг бид ерөнхийдөө яг өргөн барьсан мэдээлэл юунуудыг статистик сар болгон төсвийн гүйцэтгэлийн мэдээг тэр чигээр нь байршуулж байгаа. Энэ дээр миний түрүүнд хэлсэн иргэдийн төсөв гээд энийг дахин боловсруулалт хийгдэж яах вэ бас үнэхээр энэ орон тооны хүрэлцээ, цаг зав энэ тэр юм байгаад байгаа л даа. Бид иргэдийн төсвийг нэг жилд яг төсөв батлагдангуут нэг хийж байгаа юм. Төсвийн гүйцэтгэл гарсны дараа бас ингэж..., уг нь сар болгон гаргадаг тэр статистикийн мэдээллийг нь иргэдэд ойлгомжтой байдлаар яг тийм зураг хэлбэрээр хэн ч ороод үзсэн ойлгохоор ингэж гаргах ёстой болчихоод байгаа юм. Тэгэхээр яах вэ энэ дээр мэдээж орон тоо, хүн хүчний ийм асуудлууд.../минут дуусав/

Ж.Золжаргал: Ганбат дарга 4 номер.

Ж.Ганбат: Ийм юм байгаа юм. Тэгээд бид яах вэ сая гишүүдийн хэлж байгаа манайхан, би энэ юуны 2023 оны Үндэсний аудитын газраас шилэн данс дээр

хэрэгжүүлэлтийн энэ юуг сая би энд авчихлаа л даа. Би энийг шаардлагатай гэвэл гишүүдэд танилцуулчих уу? Энэ аудитын юмыг.

Ж.Золжаргал: Тэгье.

Ж.Ганбат: Аудит ийм дүгнэлт 2023 оны жилийн эцсийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шилэн данс дээр аудитад хамрагдсан байгууллагууд тайлант онд төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбогдсон ил тод мэдээлбэл зохих мэдээллийн 2,8 хувийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, 3,5 хувийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн гэдэг ийм юм хэлсэн байна.

Гаргасан зөрчлүүд тайлант онд төсвийн төрийн өмчит орон, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн нийт 168 байгууллагад нийт 29,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 393 удаагийн тендер шалгаруулалт, худалдан авалт зохион байгуулсан мэдээллийг ил тод мэдээлээгүй, 140 байгууллага 83,5 тэрбум.../минут дуусав/

Ж.Золжаргал: 4 номер нэмэлт цаг өгөөрэй.

Ж.Ганбат: 140 байгууллага 83,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 503 удаагийн худалдан авалтын үйл ажиллагааны мэдээллийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 342,7 тэрбум төгрөгийн 6448 гүйлгээг 606 байгууллага мэдээлээгүй, 473 тэрбум төгрөгийн 5924 гүйлгээг 261 байгууллага хугацаа хоцроосон гэх мэтчилний ийм зөрчлүүд илэрч байсан талаар аудитын байгууллагууд 2023 оны гүйцэтгэлээр аудитын байгууллага тогтоосон байна. Тэгээд мөн аудитаар Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмжийг 1024 байгууллагад, зөрчил арилгуулах албан шаардлагыг 684 байгууллагад, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг 56 байгууллагад тус тус хүргүүлж ингэж ажилласан гэдэг ийм аудитын.../минут дуусав/

Ж.Золжаргал: Их чухал мэдээлэл өгч байна. Баярлалаа. Би энэ түрүүн Мөнхбат гишүүний асуусан асуулт дээр нэмээд, саяын таны өгсөн мэдээлэл дээр нэмээд холбогдуулаад асуумаар байна л даа. Ингээд нөгөө хуулиа биелүүлэхгүй, тайлангаа хугацаанд нь өгөхгүй иймэрхүү албан тушаалтнууд дээр арга хэмжээ авсан жишээнүүд байна уу? Хэчнээн хүн саяын зөрчлүүдээс болоод арга хэмжээ авагдсан бол гэж? 4 номер.

Ж.Ганбат: Энэ дээр ийм байна л даа. Нийтдээ яг шилэн аудитор Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмжийг 1024 байгууллагад, зөрчил арилгуулах албан шаардлагыг 684 байгууллагад, холбогдох албан тушаалтанд нь хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг 56 байгууллагад 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар хүргүүлж байсан юм байна. Тэгэхээр яг хариуцлага тооц гэдэг дээр 56 байгууллагын албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар өгч байсан юм байна шаардлага.

Ж.Золжаргал: Би энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой 2, 3 хуулийн заалт ерөнхий мэдээлэл болгоод өгчихье. Төсвийн тухай хууль дээр жишээ нь хэрвээ тэр албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гээд. 70.2 дээр нь болохоор тухайн жилийн төсвийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангах талаар арга хэмжээ

хэрэгжүүлээгүй байвал ажлаас халах үндэслэл болно гэсэн заалт байгаа. Тэгээд 70.3 дээр төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно. 70.4.Төсвийн ерөнхийлөн захирагч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн төслийг боловсруулж, батлуулахдаа үндэслэлгүй тоо мэдээнд тулгуурлан батлуулсан нь төсвийн гүйцэтгэлээр тогтоогдсон бол уг албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно гэх мэтчилэн энэ юун дээр хуулийн заалтууд нь их тийм хүчтэй, ноцтой тиймэрхүү заалтууд байгаад байгаа юм.

Тэгээд яах вэ энэ болгон дээр төсвийн тэр тоо, үндэслэл дээр ч маргаантай юмнууд зөндөө бий. Ер нь энэ жил 25 оны төсөв батлахад бид чинь маш их хэлэлцүүлэг болж, хориг тавьж ийм юм боллоо шүү дээ. Тийм болохоор олон нийтийн анхаарал их орчихсон, мэргэжлийн хүрээллийнхэн төсвийн гүйцэтгэл, төлөвлөлт, хяналт дээр ингээд илүү их орж ажиллана гэдэг нь ойлгомжтой байгаа. Тийм болохоор тэр албан тушаалтнуудад хариуцлага тооцох хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх тал дээр цаашдаа их анхаарч ажиллах шаардлага бий болж байна гэж тэмдэглэж хэлмээр байна.

Тэгээд ажлын хэсгээс би асуулт асууя. Энэ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүртгэх, кодлох, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам гээд. Мөн Сангийн сайдын 18 оны 295 дугаар тушаал Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам, аргачлал эдгээрт заасан журам, аргачлалын хэрэгжилт ямархуу түвшинд хэрэгжиж байгаа бол гэдэг асуулт асууя. 5 дугаар микрофон нээж өгнө үү.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Асуултад хариулъя. Төсвийн ангилал гэдэг бол Төсвийн тухай хуулиар зааж өгсөн байдаг. Төсвийн тухай хуулиар бид төсвийгөө 5 ангилалд хуваана гэхихсэн байгаа. Төсвөөр нь ялгана, байгууллагаар нь ялгана, зориулалт арга хэмжээгээр, хөтөлбөр үр дүнгээр ялгана гээд 1 дүгээрт.

2 дугаарт бид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар манай энэ ангилж байгаа энэ ангиллууд маань олон улсын жишигт нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл олон улсын жишигт нийцэж байж, олон улс өөрөө энийгээ хүлээн зөвшөөрч, манай улсын төсөв, санхүүг үнэлж, бодитой, бодитой бус байна, эрсдэлтэй, эрсдэлгүй гэдгийг тогтоож байгаа. Тэгэхээр энэ дагуу бид яг энэ ангиллыг бол тогтоосон. Энэ дээр хяналт тавих асуудал яаж явж байна вэ гэхээр төсвийн бид нарын ашиглаж байгаа цахимжуулсан энэ программ маань өөрөө зөвхөн энэ ангиллаар орж ирж татагдаж байгаа, гүйцэтгэл яг үүгээрээ гарч байгаа. Тэрнээс өөр ангиллаар бол төсөв дээр тоо тавьж оруулах боломжгүй.

Ж.Золжаргал: Журам, тушаалын хэрэгжилт асуусан тийм ээ. Түрүүний нөгөө дугаар журам, тушаалууд тэд нарынхаа аргачлалыг ашиглаж байгаа 278, 295. Энэ 295 дугаар тушаал, Засгийн газрын 278 дугаар тогтоол гээд эд нарын хавсралт дээр маш тийм боловсронгуй хүснэгтүүд байна лээ шүү дээ маягтууд. Тэгээд тэрийгээ бөглүүлээд, хэрэгжүүлээд ингээд тавиад байх юм бол хэн ч харсан ойлгомжтой болохоор тэгж харагдаж байна лээ. 4 номер.

Ж.Ганбат: Сангийн яаман дээр Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийн талаар цахимжуулах асуудлыг

хэрэгжүүлээд сүүлийн 3, 4 жил болж байгаа. Энэ хүрээнд төлөвлөлтөөсөө эхлээд гүйцэтгэлийг нь хүртэл цахимжуулчихсан байгаа. Ирэх дараагийн жилийн төсвийн төсөл боловсруулахад, хавар төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахаас эхлээд цахимаар саналуудыг нь авч байгаа. Тэр программ дээр тухайн хүсэлтээ илгээж байгаа байгууллагууд өөрөөр хэлбэл хуулийн шаардлагаар хангасан, зураггүй, төсөвгүй, тэр хуулийн шаардлага хангаагүй төсөл, хөтөлбөрүүдийг тэр цахим программаар хүсэлтээ илгээх боломжгүй байдаг юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ маань бид хамгийн том дэвшилттэй юм хийж чадсан нь зураггүй, төсөвгүй ийм объект бол хуулийн шаардлага зөрчиж өргөн баригдах боломжгүй ийм болгосон.

Ингээд тэр хүсэлтээ ирүүлсэн дээр нь бүх саналыг нь төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн санал дээр нь үндэслэж байгаад, эрэмбэлж байгаад, ингээд төлөвлөлт талдаа тусгачихсан байгаа. Нөгөө талдаа санхүүжилтийг нь бид урьд нь цаасан хэлбэрээр бол нөгөө ирүүлдэг байснаа бас цахим болгоод, тухайн шатад жишээ нь хөдөө орон нутагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэл цахимаар Сангийн яаманд ирдэг. Яг энэ ард дэлгэц дээр гарна харвал. Яг энэний дагуу гүйцэтгэл нь Сангийн яаман дээр төсвийн ерөнхийлөн захирагч нараас хянагдаад, яг тэр гүйцэтгэл ингээд тэр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа хувийн хэвшлийн байгууллага тэр гүйцэтгэлээ хойноос нь биеэрээ хөөцөлдөхгүйгээр манайх яг юун дээр захиалагч яаман дээр хэд хоног хянагдаж байна, тэрнээс Сангийн яам руу явсан, үгүйг нь тэндээсээ гардаг. Сангийн яам дээр ирэнгүүт манай санхүүжилт эрх нь нээгдэж байна уу, хэзээ санхүүжилт гэдэг нь харагдана, буцсан бол буцсан нь харагдчихдаг. Яагаад буцсан гэдэг үндэслэлүүд нь харагдаад ийм байдлаар цахимжуулаад хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр ямар нэгэн байдлаар бид гүйцэтгэгч захиалагч байгууллагуудыг хүндрэл учруулахгүйгээр цахимжуулаад, энийг бол ер нь 100 хувь бол цахимжуулчихсан. Тэгээд энэний үр дүн бол хэрэгжилт маш сайн байгаа. Бид цахимаар ирүүлээгүй байгууллагуудын хөрөнгө оруулалтын санал болон гүйцэтгэл санхүүжүүлэх ийм ямар ч боломжгүй болгочихсон. Бүх юмыг цахимжуулаад энэтэйгээ уячихсан учраас. Саяын хэлсэн тэр юунууд бол бүрэн хангагдаад явж байгаа.

Зүгээр яах вэ сая энэ төсвийг 2025 оны төсвийг Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж явж байх явцад нэг асуудал хүндрэл учруулаад байгаа нь нөгөө төсөвт өртгийн нэмэгдэл байгаа. Бид үнэхээр сая Засгийн газраас төсөв өргөн барихдаа төсөвт өртгийн нэмэгдлийг аваагүй. Энэ төсөвт өртгийн нэмэгдлийг энийг яаралтай журамлах, энийг ямар тохиолдолд энэ төсөвт өртгийн нэмэгдлийг авах ёстой вэ энэ тэр гэдэг дээр Барилгын яам, Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам, дэд бүтцийн яамнуудтай хамтарч энэ асуудлыг, Үндэсний аудитын байгууллагатай хамтарч энэ асуудлыг, Барилгын хөгжлийн төвтэй хамтарч үүнийг боловсронгуй болгох асуудал дээр Засгийн газар ажиллаад, энийг 2026 оны төсөв дээр оруулж ирнэ. Мөн сая төсөв батлагдсан дагалдах тогтоол дээр ч гэсэн ийм үүрэг хугацаатай өгөгдсөн үүргүүд байгаа.

Ж.Золжаргал: 5 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Веб сайтыг нь энэ ард гаргачхаж байгаа юм. Энэ веб сайт нь давуу тал нь юу вэ гэхээр бид төлөвлөхөөс нь эхлээд бүх зүйлүүд нь процесс нь энэ дээр явчхаж байгаа юм. Түрүүний нөгөө ярьсан кодчиллол энэ дээр гарч ирж байгаа юм. Хэдэн онд эхэлсэн бэ гэдэг нь. Дээр нь энийг ашиглалтад орсон объектуудын зургийг нь бид бас авч тавьж байгаа юм. Өөрөөр

хэлбэл дараа нь барилгын ашиглалт хэр удаан хугацаанд үргэлжлэх вэ гэдгийг үүгээр тооцох гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл их засвар хэзээ орох вэ энэ барилга дээр гэдгийг мэдэх гээд байгаа гэсэн үг. Тэгээд захиалагчийн хяналтыг ихэвчлэн орон нутаг тавьж байгаа. Орон нутаг нь тэрийгээ захиалагчийн хяналтаа зөв хийсэн үү, үгүй юү гэдэг зүйлийг л үүгээр гаргаж ирэх гээд байгаа гэсэн үг. Тэгээд энэ бас өөрөө нөгөө яг хөрөнгө оруулалтын программын хувьд маш том дэвшлийн ийм зүйл болчихоод байгаа шүү.

Энэ publicinvestment.gov.mn гэж байгаа. Энэ бас та гар утсан дээрээ энэ аппликэйшнийг татаад суулгачхаж болно. Гар утасных нь гар утсанд ашиглахад энгийнээр маш их амархан болчихсон байгаа. Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ерөөсөө энэ веб сайтаар асуугаад л явчихна. Доод тал нь бол бид энэ гүйлгээ төсөл болгоны доод талд нь тавьчихаж байгаа юм. Жишээ нь захиалагч хэд хоногт хянах вэ, Сангийн яам хэд хоногт хянах вэ, компанийн данс руу орсон уу, ороогүй юу, хэдэн хувийн гүйцэтгэлийг эхэлж өгсөн бэ, дараа нь хэзээ өгсөн бэ гэдэг нь бүгд ил тод болчихсон ийм зүйл байгаа.

Ж.Золжаргал: Гишүүд асуулт асуулаа. Үг хэлэх, санал хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү? Байхгүй. Пунсалмаа гишүүн үг хэлэх юм уу, үгүй юү? Пунсалмаа гишүүн үг хэлнэ.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Өнөөдөр сургууль, цэцэрлэг хүртээмжийн асуудлыг иргэд маш их ярьдаг. Зам, гүүр тавиулах санал хүсэлтийг иргэд өгөхөөр хэлдэг. Гэхдээ энийг төрийн байгуулалтын систем рүү яаж нэвтэрч орж хэлэхээ тэр бүрчлэн мэдэхгүй байна. Тэгэхээр энэ системийг хэрэглэгчдэд амархан, ойлгомжтой болгох тал дээр нэлээн дорвитой ажиллах шаардлагатай байна. Энийг яамны зүгээс алхмуудаа тодорхой болгоод, энэ нэг их удаашралгүй энэ зүйлийг хийх боломж, бололцоогоо эрэлхийлэх хэрэгтэй байна.

2 дугаар зүйл нь төрийн байгуулалтын системийн хувьд зарим санхүүгийн мэдээллийн шаардлагууд ил тод байхгүй байна. Дансны мэдээллүүд сул байна. Тэгэхээр энэ болгоныгоо хянах, тэгээд хянаж тодорхойлоод, энийг эргүүлээд буцаагаад мэдээллийг нь дор бүр нь нөхөж оруулах гэдэг ийм механизмыг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Цаашлаад энэ хянах энэ механизмаа цахимжуулах, энийг илүү хялбаршуулах, техникийн дахин дараачийн түвшний ахиц нэвтрүүлэх ийм шаардлагатай гэж үзэж байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Тэгэхээр та бүхэн сая Пунсалмаа гишүүний хэлсэн үгийг анхаарч сонссон байх. Ганбаатар гишүүн ч түрүүн хэлсэн, би эхэнд нь танилцуулга санал хэлэхдээ хэлсэн. Мэдээлэл байна, мэдээлэл маш их байна, маш их мэдээлэл цахим руу орж байна. Та бүхний саяын харуулсан веб сайт байна, Ил тод гээд байна, iltod.mof, тэгээд шилэн данс байна. Ингээд тал талд маш их мэдээлэл орж байна. Хэрэглэхэд, хүн ороод харахад их төвөгтэй байна. Яг тэрүүгээр нь мэргэшсэн хаана ямар мэдээлэл байгааг нь мэддэг хүмүүс л орж ажиллахгүй бол төвөгтэй байна. Үүнийг хийхийн тулд түрүүн жишээ санал та бүхэнд танилцуулсан шүү дээ. Ингээд харж байхад бол их том систем хэрэггүй юм байна, аль хэзээний системүүд чинь байна. Нэгтгэсэн, хялбаршуулсан UX дизайнтай тийм хялбар, энгийн байдалтай болох, тэр нь нөгөө Төсвийн тухай хууль, ил тод, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны хууль дээр бүгд л байгаа. Мэдээлэл ойлгомжтой байх ёстой гээд. Тийм нэгдсэн зүйлийг хийх шаардлага байна.

Тэгээд энэ тал дээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам анхаараад Шилэн штаб байхаа, Шилэн штаб байгуулчихсан ажиллаж байгаа юм байна лээ. Тэгэхээр та бүхэн Сангийн яамтайгаа хамтраад мэдээллийг цэгцлээд, хүн ороод харахад амархан байдаг. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг сар болгон тайлагнаж байх хуулийн заалттай. Тэр хуулийн заалт нь хүнд ойлгомжтой, ороод хялбархан хараад, цаашаагаа нарийн юмнууд руугаа задарчихдаг цаад мэдээллүүд бол байгаад байна шүү дээ. Ийм байдалд оруулах шаардлагатай байна гэдгийг цохон тэмдэглэмээр байна. Тэгээд бид Байнгын хорооны гишүүдтэйгээ дахиж энэ асуудлыг ярина. Хамгийн гол нь шууд янз бүрийн тогтоол гаргахаас илүү эхлээд энэ ажил хариуцаж байгаа хүмүүстэйгээ ойлголцох хэрэгтэй. Тэгэхээр ажлын шугамаар дахиад мэдээлэл солилцоод, дүгнэлтээ, протокол дүгнэлтээ бичээд та бүхэнд хүргүүлчихнэ. Тэгээд яаж тэр нэгдсэн мэдээллийн цэсээ нэмж оруулах вэ гэдэг дээр хамтарч ажиллая гэж.

2 дугаарт нь энэ хууль дээр байгаа төсвийн мэдээлэл үнэн зөв байх ёстой, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг хийсэн байх ёстой. Хэрвээ хийгээгүй бол ерөнхийлөн захирагч нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүртэл арга хэмжээ авна энэ тэр гэсэн ийм том заалтуудтай. Тэгэхээр энэ оролцоог хангах, ойлгомжтой байх, ил тод байх гэдэг дээр хаана хаанаа анхаарч ажиллах шаардлагатай байна. Энэ тэгээд бүх суурь бааз нь хангалттай бий болчихсон байна. Одоо үүнийгээ хэрэгжүүлэх дээр анхаараад, мэдээллээ нэгтгээд, ойлгомжтой тавиад явах юм бол нэмэлт нэг их зардал ч гарах нь бага юм байна, хэрэгжих нөхцөл бүрдсэн байна гэж үзэж байна. Өнөөдрийн, гишүүд үг хэлж дууслаа.

12.09 цаг

Өнөөдрийн Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурал өндөрлөж байгааг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА